

ЗҮҮН ХОЙД АЗИ БА ЧИНГИС ХААНЫ ТӨРИЙН УРАГ БАРИЛДАХ ЁСОН

Д.Энхцэцэг *

Эмэгтэй хүн, эх хүн хүн төрөлхтний нэгэн хэсэг тул өрх гэр, төрт улс, дэлхий дахинд үзэсгэлэн гоо, саруул ухаант бүсгүйчүүдийн үүрэг нэн чухал байсаар ирсэн. Түүх шашдир арвин монгол угсаатны түүхэнд “Монголчуудын зуун” хэмээн нэрлэгдсэн тэр л эрин үед дэлхийг донсолгож, гавъзат үйлсийг бүтээсэн баатарлаг эрс олон ч тэдний ололт амжилтын үндэс болсон *“түүхийг чимээгүй бүтээгч”* эмэгтэйчүүд өөрсдийн орон зайгаа хэдийн эзлэн буурал түүхийн торгон хуудаснаа тэмдэглэгдэн үлджээ. Нийгмийн аливаа өөрчлөлт, явц бүхэн аугаа их үйл явдал байдаг болохоор тэр бүхэн эмэгтэйчүүдийн оролцоогүйгээр биелж байсан гэвэл эндүүрэл болох буй за. Монголын эмэгтэйчүүдийн өрх гэр нийгэмд гүйцэтгэсэн олон үүргийн нэгийг нөгөөгөөс салгах аргагүй цогц зүйл агаад түүхийн бодит хэрэглэгдэхүүнд тулгуурлан тоймлон авч үзвэл хамгийн түрүүн эмэгтэй хүн-эх хүн, *ижий байх үүрэг* ...

Монголын эмэгтэйчүүдийн нийгэм-улс төрийн амьдралд оролцох оролцоог илтгэх нэг өвөрмөц зүйл нь *“төрийн ураг барилдахуй” хэмээн эрхэм ёсон-Монгол хаадын алтан аргамжийн хэлхээ болж байлаа*. Чингис хаан олон Монгол аймаг эсгий туургатныг эрхэндээ хурааж өөрийн төрөл төрөгсөд, ээж дүү нар, нагац нараар захируулан Дундад Азийг дэд хүү Цагаадайд, Сибирь Кипчакийн талыг ахмад Зүчид соёрхон олгосон байна. Харин Ойрад болон Түрэг, Уйгар, Киргиз гаралтай хүчирхэг аймаг ханлигуудын ноёдыг өөрийн гүнж, охид, татвар хатадтай ураглаж төрийн өвөрмөц дипломат бодлого явуулж байжээ. Тухайлбал: Алаха бэхи охиноо –Онгуд аймгийн Буяншибалд, Ал Алалтун бэхи – гүнжийг Уйгурын Идуйд, Сэцэйхэн бэх (Чэцэйхэн) бэхийг Ойрадын ноён Хутага бэхийн хүү Иналчуд тус тус ураглажээ. Эдгээр охидоо түрэг овог аймгуудын ахлагч, зонхилогч нар эртнээс зүүж байсан *бэхи* (бег) цолыг соёрхсон нь *өөрийн охин ургийг тэдгээр овог аймгийн дээд эзэн болгон улс төрийн эрх мэдэл тэдний гарт төвлөрөх болсныг илтгэсэн, өөрийн гол түшиг тулгуур* гэж үзэж байсантай холбоотой.¹

Цагаан татаар буюу соёлжуу татарын нэг аймаг Онгуд аймаг эртнээс Хятад, Хятан, Уйгуртай аж ахуй соёлын харилцаатай, Наймантай адил уйгуржин монгол бичигтэй, хүн ам олонтой хүчирхэг аймаг, түүний захирагч нь Алахуш Дигидхури Чингис хааны Наймантай байлдахад (1204) онцгой гавъяа байгуулж, Чингист дагаар ирсэнд хаан 88 гавъяатны нэгээр өргөмжлөн, мянганы ноён болгож хааны гүнжээр шагнасан нь цэрэг-улс төрийн төдийгүй аж ахуй соёлын

* МУИС, НШУС-ийн багш

¹ Ж. Урангуа, Д. Энхцэцэг. Монгол хатад..УБ., 2000.т. 69-70

хөгжилд ихээхэн ач холбогдолтой болжээ. Монголын нууц товчоо зэрэг түүхийн сурвалжид тэмдэглэснээс үзвэл Чингис хаан дагаар ирсэн Онгуд аймгийн эзэн Алахуш дигидхурийн хүү Буяншбалд сайшаан соёрхож Алаха бэхи охиноо хатан болгон өгөхдөө:

*...Харайхад минь хөл болж
Хазайхад минь түшиг болж
Халтирахад тах болж
Халамж тус хүргэхээ
Хайрт Алаха минь мэдтүгэй
Энэ бие хэврэг боловч
Эрхэм нэр мөнх шүү
Саруул ухаанаас илүү сайн нөхөр үгүй
Мунхаг ухаанаас илүү муу дайсан үгүй
Эрхэм итгэлтэн олон боловч
Энэ бие бүхнээс итгэлтэй
...Хатуужиж явбал хамгаас хайрлалтай
Ариун явбал аминд тустай²*

хэмээн сургаж төр улсын чухал үүргийг хүлээлгэж байжээ. Алаха бэхи эцгийн итгэлт шадар түшмэдийн хувиар үүргээ нэр төртэй биелүүлж төрийн үүргийг түшицсэн. 1219 онд Чингис хаан Дундад Ази, Сартуул иргэнийг дайлах үед ... гүнж Алаха, дүү Отчигин ноён хоёроор тус тус говийн өмнө умарын төрийн хэргийг захируулахаар шийдвэрлэж “Төр захирах гүнжийн тамга гэсэн гуулин тамга гүнжтэнд олгож байжээ.”³

Энэ тухай Сүн улсын Монгол-Татарын бүрэн тэмдэглэлд “... Гүнж бол сэцэн мэргэн бодлоготой, хаан ийш тийш аян дайнд морилохуйд төр улсын их засгийг зөвлөн захируулахаар үлдээдэг тул цэрэг эргэлзээгүйгээр явах үед *гүнжийн гавъяа их*” гэж тэмдэглэжээ.

Тухайн үеийн хүчирхэг овог аймгуудын нэг Уйгар аймаг 1208 онд Чингис даган ирж “Чингис хаан соёрхвол алтан бүсний чинь гархинаас барьж ариун дээлийн чинь үртэснээс олж, тавдугаар хүү чинь болж хүчээ өгье” гэж элч илгээсэнд Чингис хаан тэр үгийг сонсоод ихэд таалж: “Охиноо өгье. Тавдугаар хөвгүүн болтугай. Алт мөнгө, сувд тана, хоргой, хээт оёмол торго, ... авч иртүгэй” хэмээн илгээхэд Уйгурын эзэн 1211 онд Хаврын тэргүүнд сард Хэрлэнгийн хөдөө аралд хаанд соёрхогдов хэмээн ирсэн. Уйгарын эзэн Идүйдэд Ал алтун нэрт охиноо өгөхдөө:

*Хатагтай хүнд гурван эр бий
Анхны эр нь алтан төр
Түүний дараах эр нь ариун нэр
Түүний удаах эр нь авсан эр мөн билээ.
Алтан төрийг хатуужин дагавал
Ариун нэр ирнэ
Ариун нэрийг бэхэлбэл
Авсан эр ангид үл одно⁴*

хэмээн сургаал юугаан хайрлан төр ёсыг өндөр өргөж явахыг сануулж байжээ. Мөн үүний хамт Хубилай ноён Харлугуудын Арслан хан дагаж ирсэнд “Чингис хаан Арсланг байлдсангүй дагав хэмээн сайшаан соёрхож, охиноо өгье хэмээн

² Лу, Алтановч. УБ., 1990.т.98-99 (МНТ. УБ., 2005.т.121-122)

³ Ж. Урангуа, Д. Энхцэцэг. Монгол хатад. УБ., 2000. т.68

⁴ Ж. Урангуа, Д. Энхцэцэг. Монгол хатад.. УБ., 2000.т. 69-70

зарлиг болгов.⁵ Чухам ямар нэрт охиноо өгсөн нь тодорхойгүй. Ургын бодлогоор Харлугийг нэгтгэн хожим Арслан хааны хөвгүүн Есөн буха, түүний хүү Хундар нар Монголын төрд үйлчилж төрийн хүргэд байжээ. “Юань ши” ба хятад сурвалжид *Тулай гүнжийг* өгч ван өргөмжлөв. Арсланг үгүй болсон хойно хүү Есөн буха гүнжийг дагав гэжээ.

1207 онд Чингис хаан ахмад хүү Зүчийг илгээн ойн иргэдийг эзлэн авахад Ойрадын эзэн Хутуга бэхи түмэн ойрдаа авч дагаар ирсэнд түүний хүү *Иналчид өөрийн охин Сэцэйхэн /Чэчэйхэн/ гүнжийг* өгөв. Охиндоо хандаж: “Эрт унтаж орой хэвт ... Өдөр шөнө нэгэн сэтгэлээр хатууж, амны ухаан билгээ тогтоо Эс сурсан мууг энд тавьж (үлдээж) од. Сурсан сайныгаа аваад од. *Ойрад иргэнээ сэлбэн холбон соёрхогтун*” хэмээсэн.⁶ Иналчийн ах Төрүлчид Зүчийн охин *Улхуйн гүнжийг ураглажээ*. Ийнхүү Чингис хаан өөртөө дагаар ирсэн аймаг ханлигуудтай найртай харилцах олон овог аймгуудыг өөртөө нэгтгэн захирч байх зорилгоор тэдгээр аймгийн “хан“, “бэхи“ нарт өөрийн сурвалжит гүнж охидыг хатан болгон өгч байсан нь эзэн хааны дипломат бодлого байжээ.

Монголын нууц товчоонд дээр дурьдсанаас гадна “Охин ураг”-аар соёрхол хүртсэн Чингис хааны хүргэдийн тухай мэдээ цөөнгүй бөгөөд тэр нь дээрх “төрийн ураг барилдахуй ёстой” шууд хамааралтай болно. Тухайлбал Хонгирад аймгийн Улар хүргэн, Олхонууд овгийн Хинхиодай Буха хүргэн (нууц товчооны зүйл 120, зүйл 202 хоёр удаа тэмдэглэгджээ) Буха хүргэн (нууц товчооны зүйл 137-д бий) жалайр овогт Хүн гуа-ийн хүү Мухулайн дүү гэсэн бол “Хятад сурвалжид жад буюу (харь) Баяд овогтон, Баяд Чаншигуу хоёр овогтоны Мэнгэту хиагийн хөвгүүн Өнгүр ...13 хүрээний байлдаанд гавъяа байгуулж Чингисийг дэмжсэнд охин ураг соёрхсон бололтой”, Хурил хүргэн (Хятад сурвалжид түүний нэр байдаг гэнэ. Тайчуудын Хорил буюу Хури жанжин гэж Сайшаал бичжээ.) Ашиг хүргэн (сурвалжуудын мэдээ зөрөөтэй чонос, тэлэнгүүд, сүлдэс, хонгирад овогтны аль нь болох нь тодорхойгүй), Хадай хүргэн (Ойрадын Хутуга бэхийн хөвгүүн ба Юань ши-д Янь Ан гүнжтэй урагласан гэж тэмдэглэжээ), Чихү хүргэн (Хонгирад овогтон Чигу-г гэх, Юань ши-д Өгөөдэй хааны шашдирт ... Тэмүүлэн (Ту-мань-лунь) гүнжийг Чи-ку хүргэн богтлов гэх, Рашид ад Дины сударын чуулганд Тайцзугийн дөрөвдүгээр охин Тэмүүлэнийг Хонгирад овогтны Алчи ноёны хөвгүүн Чихү хүргэнд богтлов, Монгол татарын тэмдэглэлд Чингис хааны охин Тэмүүлэнг Хонгирад Дай цэцэний хүү, Алчи ноёны хүү Чихүд өгөв гэх, Алчи хүргэн (Хонгирад овгийн Дай сэцэний ахмад хүү), Учан хүргэн (дээрх Алчи ноёны хөвгүүн-Толуйн охин Есү Бухаг богтлов гэх), Начин хүргэн (Учаны дүү Тайзу Чингис хааны ач охин Сэцэйхэнийг ураглав гэх), Буту хүргэн (Ихирэс овогтон энх цагт Чингис хааны охин дүү Бөртэ хатнаас гарсан Тэмүүлэн Гуа гүнжийг ураглаж, Тэмүүлэн гуа нөгчсөнд Чингисийн ахмад хүү Зүчийн охин Хожин бэхийг богтолжээ) гэх мэт олон хүргэдийн тухай өгүүлсэн нь *Чингис хааны төрийн бодлогод охид, гүнж нарын гүйцэтгэсэн нэгэн үүрэг ба Их Монгол улс нэгдсэн хүчирхэг байхын нэг үндэс нь дээрх ургийн бодлого байв*. Ийнхүү, Их Монгол улс эзэнт гүрний үед хэдийгээр эмэгтэйчүүд өрх гэр төрөл садны хүрээнд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан ч тухайн үеийн нийгэм-улс төрийн онцлог байдал, цаг үеийн шаардлагаас болон улс төрийн амьдралд шууд ба дам байдлаар оролцож иржээ гэж хэлж болох юм.

⁵ Монголын нууц товчоо УБ., 2005.т.121

⁶ Лу. Алтан товч. УБ., 1990.т.101 (МНТ. УБ. 2006.т.121-122)

Ном зүй

1. Ата мелик Джувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. ӨМСХХ., 1986
2. Ардажаб Э. Монголын нууц товчоо. сийрүүлсэн тайлбар.Хөх хот .,1986
3. Баяр Д. Перс номын чимэглэл зурагт хадгалагдан үлдсэн дундад зууны үеийн Монголын
4. уран зургийн зарим мэдээ. / Studia historia. 24.9.,УБ.,1990
5. Баясах Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр баримт бичиг. УБ., 2005
6. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл. (Асралт ,Хөх –Өндөр нар) Хайлаар., 1985
7. Далай Ч. Монголын түүх. Тэргүүн, дэд дэвтэр. УБ., 1996
8. Жүгдэр Ч.Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987
9. Карпини Джс. и Рубрук Г.Путешествие в восточные страны Плато Карпини и Вильгельма Рубрука . М., 1957
10. Кловияо-ийн зүүн тийш элчилэгдсэн тэмдэглэл. ӨМҮХХ., 1994
11. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987
12. Монголын нууц товчоо. УБ. , 2005
13. Монгол улсын түүх . дэд боть. УБ., 2003
14. Моррис Россаби. Хубилай хаан, түүний амьдралын цаг үе..
15. Мункуев Н.Ц. Мэн-Да Бэйлу (Полное описание монголо –татар) М., 1975
16. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал .УБ.,1978
17. Оссон Д.История Монголов от Чингис хана до Тамерлана . И., 1937
18. Отахи Мацуво. Хубилай хаан. УБ., 1991
19. Пауль Рачновский. Чингис хаан түүний амьдрал ба өв. /Англи хэлнээс орчуулсан Л.Мөнх-Эрдэнэ / УБ., 2006
20. Рашид-ад Дин. Сборник летописей. Том II. М-Л., 1952
21. Рашид –ад –дин .Судрын чуулган. I ,II ,III УБ.,2000
22. Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. Доод дэвтэр.Хөх хот
23. Сайн жаргал . Шаралдай . Алтан ордны тайлга . Бээжин ., 1983
24. Сэцлэглэгсдийн чуулганы намага (Монголын хаадын төрийн товчоон. Аблагачи баатар хаан түрэг хэлээр зохиов). Хөх хот., 1999
25. Урангуа Ж., Энхцэцэг Д. Монгол хатад. УБ., 2000
26. Урангуа Ж., Энхцэцэг Д . “Монголын эмэгтэйчүүд XIII зуунд” (Үлэмжийн их Чингис хаан . (эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2002
27. Энхцэцэг Д. Монголын нууц товчоо ба эмэгтэйчүүд .УБ., 2008
28. Юань улсын судар. УБ., 2002